



# ХУДАЛДАА

*Хэнтий - 2013*

ХЭНТИЙ АЙМАГ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## 1. Худалдааны салбарын үүсэл хөгжил

Монгол улсын худалдааны салбарын үүсэл хөгжил 90 гаруй жилийн түүхтэй бөгөөд хүнсний болон өргөн хэрэглээний барааны эн тэргүүний хэрэглээг хангах зорилгоор эд хэрэглэгчдийн анхны хоршоо байгуулагдсанаар өнөөгийн худалдааны салбарын хөгжлийн эх үүсвэр тавигдсан. Худалдааны салбарын хөгжлийн явцад гадаад худалдаа, худалдаа бэлтгэл, эдийн засгийн хамтын ажиллагаа зэрэг дэвшилттэй шийдлүүд гарч ирсэн.

Гадаад худалдааны тэнцэл 2.1 тэрбум ам. долларын алдагдалтай гарч, өмнөх оныхоос 11.3 хувиар буурсан байна. Экспортын хэмжээ өмнөх оныхоос 2.6 хувь, импорт 5.6 хувиар буурчээ. Улсын хэмжээнд бө өний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт 2013 онд 16.6 их наяд төг болж, өмнөх оныхоос 24.1 хувиар өсчээ.

Зах зээлийн нийгэмд шилжиж худалдааны салбарын нэгжүүд хувьд шилжиж худалдаа бэлтгэл, нийтийн хоолны үйлчилгээн дэх чанарын хяналт алдагдаж, ард иргэдийг экспортын болон үндэсний экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах асуудал тавигдаж байгаа билээ. Юуны өмнө алслагдсан аймаг орон нутгийн хэрэглэгчдэд бараа худалдаалах, тэдгээрээс мал аж ахуйн бүтээгдэхүүнийг худалдан авах бөөний худалдааны сүлжээ бүрдүүлэх төдийгүй интернэтэд суурилсан эргэх буцах мэдээллийн урсгалыг багтаасан зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлага тавигдаж байгаа юм. Иймд хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг байнга судлан түүнд бараа үйлчилгээг нийцүүлэх, зах зээлийн мэдрэмжийг олж харах талаар шинийг эрэлхийлэн ажиллах хэрэгтэй байна.

Худалдааны салбарт худалдаа нийтийн хоол зочид буудлын салбарын эдийн засгийн үзүүлэлтэд ажиллагсадын тоо, бараа бүтээгдэхүүний борлуулалт, зардал үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүд ордог.

## Худалдааны салбарын хөгжлийн тү ү хэн ү е шатууд:

Худалдааны салбарын суурь тавигдсан ү е (1921-1935 он)  
o Хоршооллын худалдаа

Хоршооллын худалдааны хөгжлийн ү е (1935-1959 он)  
o Улсын худалдаа  
o Хоршооллын худалдаа

Социалист худалдаа (1960-1972он)  
o Улсын худалдаа  
o Хоршооллын худалдаа  
o ХАА-н нэгдлийн худалдаа


Социалист худалдаа(1972-1990он)  
o Улсын худалдаа  
o ХАА-н нэгдлийн худалдаа

Зах зээлийн шилжилтийн ү ейин худалдаа (1990-1997 он)  
o Чөлө өт худалдаа

Олон талт чөлө өт худалдааны хөгжлийн ү е (1998 оноос хойш)  
o Олон талт чөлө өт худалдаа

Аймгийн хэмжээнд өнөөгийн байдлаар 400 орчим худалдаа үйлчилгээний ААН үйл ажиллагаа явуулдаг үүнээс нь хүнсний худалдаа эрхэлдэг 251, шатахуун түгээх үйл ажиллагаа эрхэлдэг 41, эмийн худалдаа эрхэлдэг 23, өргөн хэрэглээний барааны худалдаа эрхэлдэг 59 ААН байна.

Нийт дүнд салбаруудын эзлэх хувийн жин



Аймгийн худалдааны салбар 2013 онд 9281,1 сая төгрөгний борлуулалт хийсэн нь өмнөх оныхоос 284.5 сая төгрөгөөр буюу 3.1 %-иар өссөн борлуулалттай байна.

2013 онд 1000 хүнд ноогдох борлуулалтын хэмжээ 134.1 сая.төг байгаа нь өмнөх 2012 оноос 6.0 сая.төг-өөр өссөн үзүүлэлт гарлаа.

2013 оны өргөн хэрэглээ бараа үйлчилгээний үнийн өсөлт 2012 оныхтой харьцуулахад их байсны улмаас нийт гаргалт өссөн байдалтай харагдаж байна.

**Худалдааны салбарын нийт гаргалт  
нэмэгдэл өртөг завсрын хэрэглээ**

*/Хүснэгт-1/*

№	Он	Нийт үйлдвэрлэлт	Нэмэгдэл өртөг	Завсрын хэрэглээ
1	2006	2488.3	364	2124.3
2	2007	3991.3	505.8	3485.5
3	2008	4691	489.6	4201.4
4	2009	4498.4	710.7	3787.7
5	2010	6442.1	776.2	5665.9
6	2011	7360.8	675.6	6685.2
7	2012	8996.6	941.0	8055.6
8	2013	9281.1	1118.4	8162.7

# 1. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

## Б.Спирмений корреляцийн хамаарал

/Хүснэгт-2/

№	Он	Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ /сая.төг/	ДНБ	Nx	Ny	Nx-Ny	d <sup>2</sup>
		X	Y				
1	2008	489.6	54741.9	1	2	-1	1
2	2009	710.7	54678.7	3	1	2	4
3	2010	776.2	86770.2	4	3	1	1
4	2011	675.6	118001.4	2	4	-2	4
5	2012	941.0	177746.6	5	5	0	0
6	2013	1118.4	242570.6	6	6	0	0
Дүн							10


Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ үр ДНБ-нд хэрхэн нөлөөлж байгааг хамаарлын хүчийг хэмжих энгийн арга болох Спирмений корреляцийн аргаар тооцлоо. Ингэхэд: ..

$$\rho = 1 - \frac{6 \sum d^2}{n(n^2 - 1)} = 1 - \frac{6 * 10}{6(36 - 1)} = 0.7$$

Коэффициентийн утга / 0.7/ буюу хүчин зүйлийн үзүүлэлт үр дүнгийн үзүүлтэнд шууд хамааралтай байна.

Он	Худалдааны салбарын нийт гаргалт, /сая.т	3 үеийн голчилсон хөвөгч дундаж	Хөвөгч дундаж ба бодит тооны харьцаа
2005	467.1	1140.8	40.9
2006	2488.3	2315.5	107.4
2007	3991.3	3723.5	107.1
2008	4691	4393.5	106.7
2009	4498.4	5210.5	86.3
2010	6442.1	6100.4	105.6
2011	7360.8	7599.8	96.9
2012	8996.6	8546.2	105.2
2013	9281.1	-	-

Í è èò ä¿í ä ñæ ääðóóüí í ýçé ýò ðóàè éí æèí



3 үеийн хөвөгч дундажыг тооцсон нь харьцангуй жигд өсөлттэй гарлаа. 2013 оны хөвөгч дундаж ба бодит тооны харьцаа өндөр байгаа нь 2013 оны нийт гаргалтын хэмжээ өссөнтэй холбоотой харагдаж байна.

Он	Худалдааны салбарын нийт гаргалт, /сая.төг/	Абсолют цэвэр өсөлт	Хэлхээ өсөлтийн хурд (%)	Хэлхээ цэвэр өсөлт, бууралтын хурд (%)	Цэвэр өсөлтийн нэг хувьд ногдох утга
2005	467.1	0	0	0	0.4
2006	2488.3	2021.2	532.7	432.7	0.4
2007	3991.3	1503	160.4	60.4	24.8
2008	4691	699.7	117.5	17.5	39.9
2009	4498.4	-192.6	95.8	-4.2	46.9
2010	6442.1	1943.7	143.2	43.2	44.9
2011	7360.8	918.7	114.2	14.2	64.4
2012	8996.6	1635.8	122.2	22.2	73.6
2013	9281.1	284.5	103.2	3.2	88.9

2005-2013 оны худалдааны салбарын нийт гаргалт дээр динамик хандлагын шинжилгээ хийж үзэхэд 2005, 2009 онуудад өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлт бага байсан тул өсөлтийн хурд харьцангуй багассан нь харагдаж байна.

Энэ нь өргөн хэрэглээний барааны үнэ нийт гаргалтанд шууд нөлөөтэйг баталж байна. 2010 онд 2009 оныхоос 43,2 хувиар өссөн, 2011 онд 2010 оныхоос 14.2 хувиар өссөн, 2012 онд 2011 оноос 22.2 хувиар өссөн, 2013 онд 3.2 хувиар өссөн байна.

Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ ДНБ-нд хэрхэн нөлөөлж байгааг хамаарлын хүчийг хэмжих Спирмений корреляцийн аргаар тооцоход коффецентийн утга 0.7 буюу хүчин зүйлийн үзүүлэлт үр дүнгийн үзүүлтэнд шууд хамааралтай байна.

## Дүгнэлт

Аймгийн худалдааны салбар 2013 онд 9281.1 сая төгрөгний борлуулалт хийсэн нь өмнөх оныхоос 284.5 сая төгрөгөөр буюу 3.1 %-иар өссөн борлуулалттай байна.

2013 онд 1000 хүнд ноогдох борлуулалтын хэмжээ 134.1 сая.төг байгаа нь өмнөх 2012 оноос 6 сая.төг-өөр өссөн үзүүлэлт гарлаа.

2013 оны өргөн хэрэглээ бараа үйлчилгээний үнийн өсөлт 2012 оныхтой харьцуулахад харьцангуй их байсны улмаас нийт гаргалт өссөн байдалтай харагдаж байна.

3 үеийн хөвөгч дундажыг тооцсон ч харьцангуй жигд өсөлттэй гарлаа. 2012 оны хөвөгч дундаж ба бодит тооны харьцаа өндөр байгаа нь 2013 оны нийт гаргалтын хэмжээ өссөнтэй холбоотой харагдаж байна.

2005-2013 оны худалдааны салбарын нийт гаргалт дээр динамик хандлагын шинжилгээ хийж үзэхэд 2005, 2009 онуудад өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлт бага байсан тул өсөлтийн хурд харьцангуй багассан нь харагдаж байна.

Энэ нь өргөн хэрэглээний барааны үнэ нийт гаргалтанд шууд нөлөөтэйг баталж байна. 2005 оны худалдааны салбарын нийт гаргалт нь 2004 онтой харьцуулахад өсөлтгүй, 2006 оны үзүүлэлт 2005 оныхоос 432,7%, 2007 онд 2008 оныхоос 60.4 хувиар өссөн, 2008 онд 2007 оныхоос 17.5 хувиар өссөн, 2009 онд 2008 оныхоос 4.2 хувиар буурсан, 2010 онд 2009 оныхоос 43.2 хувиар өссөн, 2011 онд 2010 оныхоос 14.2 хувиар өссөн, 2012 онд 2011 оноос 22.2 хувиар, 2013 онд 2012 оноос 3.2 хувиар тус тус өссөн байна.

Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ ДНБ-нд хэрхэн нөлөөлж байгааг хамаарлын хүчийг хэмжих Спирмений корреляцийн аргаар тооцоход коффецентийн утга 0.7 буюу хүчин зүйлийн үзүүлэлт үр дүнгийн үзүүлтэнд урвуу хамааралтай байна.

Гүйцэтгэсэн

Г.Сэдэлмаа